



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 1132

Шивээговь сум

Команд штабын сургуулийн бэлтгэл ажлыг
 хангаж, зохион байгуулах ажлын хэсэг
 байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Төсвийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.2.3, Онцгой байдлын Ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/323 дугаар “Заавар батлах тухай” тушаалын хавсралт “Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын дадлага сургууль зохион байгуулах заавар”, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 10 дугаар тогтоол “Сумын 2022 оны төсөв батлах тухай”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Хүн, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчноо болзошгүй гамшиг осол, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, үйл ажиллагааны онолын мэдлэг олгох, дадлагажуулах чадвар олгох ажлын хүрээнд “Команд штабын сургууль”-ийн бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсэгийн дарга:

Ч.Сугармаа

(Засаг даргын орлогч)

Гишүүд:

Ц.Цэрэндорж

(Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Л.Алдар

(Сумын ЕЗМА-ийн Сайн дурын бүлгийн дарга)

С.Отгонбаатар

(2 дугаар багийн Засаг дарга)

П.Дэлгэрбаяр

(Цагдаагийн хэсгийн төлөөлөгч)

Д.Буяндэлгэр

(Ерөнхий боловсролын сургуулийн захирал)

Б.Даваадолгор
 (3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч)
 Х.Сувданцэцэг
 (Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
 Э.Төрмандах
 (Соёлын төвийн дарга)
 Ш.Чинболд
 “Илчлэг Шивээ” ОНӨҮГ-ын захирал
 Ц.Амарсайхан
 (Шивээ-Овоо хувьцаат компанийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэсгийн дарга)
 Ш.Буяннэмэх
 (Сумын ЕЗМА-ийн бүрэлдэхүүний Мал эмнэлэг, хөдөө аж ахуйн бүлгийн дарга)
 О.Ууганцэцэг
 (Сумын ЕЗМА-ийн Холбоо мэдээллийн тусгай бүлгийн ахлагч)
 Д.Сувд-Эрдэнэ
 (1 дүгээр багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга:

2.“Команд штабын сургууль”-ийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.“Команд штабын сургууль”-ийн үйл ажиллагаанд шаардлагатай 1,000,000 (нэг сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн “Гамшгаас хамгаалах зардал”-аас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Цэрэндорж)-д, санхүүгийн анхан шатны баримтыг бүрэн хангаж ажиллахыг нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш)-д тус тус даалгасугай.

4.“Команд штабын сургууль”-ийн бэлтгэл ажлыг зохион байгуулах удирдамжийн дагуу хангаж, хугацаанд нь чанартай гүйцэтгэхийг ажлын хэсгийн дарга (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

Сумын Засаг даргын 2022 оны 03-р сарын
23-ны өдрийн 116 дугаар захирамжийн
1-р хавсралт

ШИВЭЭГОВЬ СУМАНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ
КОМАНД ШТАБЫН СУРГУУЛИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2022.03.23

Шивээговь сум

ЗОРИЛГО: Болзошгүй гамшгийн аюулаас хүн, мал амьтан, хүрээлэн байгаа орчныг хамгаалах урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд нутгийн захиргааны байгууллага, удирдах бүрэлдэхүүн, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, иргэн, хуулийн этгээд томилгоот бүрэлдэхүүнийг сургаж дадлагажуулах, гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх, төлөвлөлтийг боловсронгуй болгох, харилцан ажиллагааг сайжруулах.

Д/д	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
Нэгдүгээр үе буюу бэлтгэл ажил хангах			
1	Команд штабын сургууль зохион байгуулах Засаг даргын захирамж гаргуулан, ажлын төлөвлөгөөг батлуулж мэргэжлийн анги, албадад хүргүүлэх	03 сарын 23-ны өдөр	Тамгын газрын дарга Ц.Цэрэндорж
2	Сумын онцгой комисс, гамшгаас хамгаалах ерөнхий зориулалттай мэргэжлийн анги, сайн дурын бүлгийн дарга, удирдлагын томилгоог тодотгон, баталгаажуулах	03 сарын 23-ны өдөр	Сумын орлогч дарга буюу гамшгаас хамгаалах штабын дарга Ч.Сугармаа
3	Гамшгаас хамгаалах ерөнхий зориулалттай мэргэжлийн анги, мэргэжлийн албадын КШС-ын үеэр хийх ажлын төлөвлөгөөг хянуулж, батлуулах	03 сарын 23-ны өдөр	Анги, албадын дарга нар
4	Сургууль зохион байгуулах захирамж, тушаал шийдвэрийн төслийг хянан батлуулах	03 сарын 24-ны өдөр	Сумын орлогч дарга буюу гамшгаас хамгаалах штабын дарга Ч.Сугармаа
5	Сумын болон бүх шатны гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх	03 сарын 28-ны өдрийн дотор	Архив, бичиг хэргийн эрхлэгч буюу сумын ОК-ын бичээч Б.Ууганбаяр
Хоёрдугаар үе буюу, сургуулийн өмнөх үйл ажиллагааны бэлтгэл ажил			
6	Томилгоожсон удирдах бүрэлдэхүүнтэй "Газар хөдлөлт, малын гоц халдварт өвчин, хүчтэй салхи, шороон шуурга" сэдвээр штабын дадлага сургууль зохион байгуулах	03 сарын 25-ны өдөр	ЗДТГ-ын дарга Ц.Цэрэндорж ОБГ-тай хамтран
7	Сумын онцгой комиссын даргын ажлын зураг болон шийдвэрийн зураг бэлтгэх	03 сарын 29-ны өдөр	ЗДТГ-ын дарга Ц.Цэрэндорж
8	Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн дарга нарын ажлын зураг болон шийдвэрийн зураг	03 сарын 29-ны өдөр	Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн дарга нар

9	Сургуулийн үеийн хөдөлгөөнт болон суурин удирдлагын байрыг бэлтгэх төхөөрөмжлөх	03 сарын 28-ны өдөр	ОК-ын гишүүн буюу бүлгийн дарга нар
10	Хүн нэг бүрийн аранзанд байх зүйлсийг бэлтгэх	03 сарын 23-ны өдөр	Тамгын газрын дарга Ц.Цэрэндорж
11	Сургуулийн үеийн хөдөлмөр хамгаалал аюулгүй ажилагаа, эрүүл ахуйн зааварчилгаа өгч, баталгаажуулсан байх	03 сарын 29-ны өдөр	Эрүүл мэндийн алба
12	Болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх гарын авлага, материал хийж тараах	03 сарын 28-ны өдрийн дотор	Сургалт, сурталчилгааны ажилтан
13	Эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх дадлага сургууль хийх	03 сарын 30-ны өдөр	ОК-ын гишүүн ЕЗМА
14	Сургуульд оролцогч гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн харилцан ажиллагааг уялдуулах, удирдлага зохион байгуулалтаар хангах	03 сарын 30-ны өдөр	Сумын Орлогч дарга
15	Сургууль зохион байгуулагдах үеийн аннос хийлгэж хэвлүүлэх	03 сарын 25-ны өдөр	ЗДТГазар
Гуравдугаар бүлэг сургуулийн үеийн үйл ажиллагаа			
16	“Цуглар” улбар шар кодтой сургуулийн дохиогоор ажиллуулах	08:00-08:30 цаг	ЗДТГ-ын дарга ОБГ-ын удирдлагууд
17	Сургууль, дадлагын үеийн холбогдох бичиг баримт, техник хэрэгсэлийг бэлтгэх, хичээл заах багш нарын бэлтгэлийг хангах	7:30 цаг	ЗДТГ-ын дарга
18	Мал амьтны гоц халдварт өвчин, авч хэрэгжүүлэх арга хэмжээ	11:00-11:30 цаг	Сумын мал эмнэлэгийн тасаг
19	Хүний халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх өвчлөлийн үеийн хариу арга хэмжээ	11:30-12:00	Сумын ЭМТ-ийн дарга
20	Танхимын хичээл сургалт болон дадлага сургуульд тасалдал, хоцрогдолгүй хамрагдах	08:00-19:10 цаг	Сумын онцгой комиссын гишүүд, Мэргэжлийн анги, албадын дарга нар
21	Өгсөн цагийн байдал дээр хамтран ажиллах	09:50-12:30 цаг	
22	Хүн нэг бүрийн аранз, үүргэвчний үзлэгт хамрагдах	08:50-09:10 цаг	
23	Сургуулийн үеийн үйл ажиллагааг баримтжуулах, сургуулийн үеийн баримт бичиг, тайлан гаргаж архивлан ОБГ-т хүргүүлэх	13:00-15:30 цаг	Нигмийн бодлогын мэргэжилтэн Бичиг хэрэг, архивын эрхлэгч
24	Сургууль эхэлсэн болон сургууль дуусан тухай ЗД-ын захирамж гаргуулах	08:00-08:30 цаг 19:00-19:10 цаг	Бичиг хэрэг, архивын эрхлэгч

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:
ЗДТГ-ЫН ДАРГА



Ц.ЦЭРЭНДОРЖ



Сумын Засаг даргын 2022 оны 03-р сарын 23-ны өдрийн 43 дугаар захирамжийн 2-р хавсралт

ШИВЭЭГОВЬ СУМАНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ КОМАНД ШТАБЫН СУРГУУЛИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

2022.03.23

Д/д	Үзүүлэлт	Нийт төсөв	Тайлбар
1	Бичиг хэргийн зардал	140,000	Команд штабын суригуулалтанд ажиллах багт шаардлагатай бичиг хэргийн материалын зардал
2	Ажлын зургийн зардал	250,000	Онцгой комиссын мэргэжлийн ангийн ажлын зураг болон шийдвэрийн план зураг
3	Хоолны зардал	310,000	Онцгой комиссын болон мэргэжлийн анги байгууллагын алба хаагчдын 1 удаагийн хоол
4	Шатахууны зардал	300,000	Зохион байгуулж буй арга хэмжээнд оролцох шаардлагатай автомашинуудад зарцуулагдах шатахуун
	Нийт	1,000,000	

Тооцоо хийсэн:
ЗДТГ-ын нягтлан бодогч: Л. Цэнд-Аюуш